

## **ГАДААД АЖИЛТНЫ АЖЛЫН БАЙРНЫ ТӨЛБӨР ТӨЛӨХ, ХӨНГӨЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ, ТӨЛБӨРИЙН ЗӨРҮҮГ БУЦААН ОЛГОХ, ТЭДГЭЭРИЙН БҮРТГЭЛИЙГ ХӨТЛӨХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ журмын зорилго нь Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 32 дугаар зүйлд заасан гадаад ажилтны ажлын байрны төлбөр төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийн зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гадаад ажилтны ажлын байрны төлбөр /цаашид “ажлын байрны төлбөр” гэх/-ийг төлөх, хөнгөлөх, чөлөөлөх, төлбөрийг зөрүүг буцаан олгох, тэдгээрийн бүртгэлийг хөтлөхөд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль (шинэчилсэн найруулга), Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль болон уг асуудлаар гадаад улсын Засгийн газартай байгуулсан хэлэлцээр, бусад холбогдох хууль тогтоомж болон энэ журмыг мөрдлөг болгоно.

### **Хоёр. Ажлын байрны төлбөр төлөх**

2.1. Ажил олгогч хөдөлмөр эрхлүүлэх гадаад ажилтны тоо болон Монгол Улсад ажиллах хугацааг харгалзан ажлын байрны төлбөрийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 32.1 дэх хэсэгт заасан хэмжээгээр тооцож, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд урьдчилан төлнө.

2.2. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажлын байрны төлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлнэ.

2.3. Ажил олгогч ажлын байрны төлбөрийг хууль, олон улсын гэрээнд тусгайлан заасан болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр хөнгөлсөн, чөлөөлснөөс бусад тохиолдолд хуульд заасан хэмжээгээр төлнө.

2.4. Монгол Улсад албан хэргээр оршин суугч, цагаач болон Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаад иргэн, мөн эцэг, эхийн аль нэг нь Монгол Улсын иргэн бол тухайн гадаадын иргэнийг авч ажиллуулсан ажил олгогчоос ажлын байрны төлбөр авахгүй.

### **Гурав. Ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх**

3.1. Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх болон Монгол Улсын Засгийн газраас стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт гэж тодорхойлсон төсөл, хөтөлбөрт ажиллах гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг Засгийн газрын шийдвэрээр хөнгөлнө.

3.2. Энэ журмын 3.1-д заасан хөнгөлөлтийн хувь, хэмжээг Засгийн газар тухай бүр шийдвэрлэнэ.

3.3. Ажил олгогч энэ журмын 3.1-д заасан хөнгөлөлтөд тухайн жилд хамрагдах хүсэлтээ жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолт, төсөл, хөтөлбөрийн танилцуулга, бусад холбогдох баримт бичгийн хамтаар хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

3.4. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажил олгогчийн гаргасан хүсэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, хөнгөлөх шийдвэрийг гаргана.

3.5. Ажлын байрны төлбөрийг хөнгөлөх тухай асуудал Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан тохиолдолд холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг уг бодлогын баримт бичигт тогтоосон хэмжээгээр хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөнгөлнө.

3.6. Энэ журмын 3.5-д заасны дагуу ажлын байрны төлбөрийг хөнгөлөх тохиолдолд ажил олгогч хөнгөлөлтөд хамрагдах тухай хүсэлтийг үйл ажиллагаа эрхэлж байгаа салбарын асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр гаргана.

3.7. Холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн ажлын байрны төлбөрийг хөнгөлөх эсэхийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухай бүр шийдвэрлэнэ.

3.8 Энэ журмын 3.1-д заасны дагуу ажлын байрны төлбөрийг хөнгөлөх асуудлыг Засгийн газрын шийдвэрийн дагуу энэ журмын 3.3, 3.4-д зааснаас өөр хугацаанд гаргаж болно.

### **Дөрөв. Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх**

4.1. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 32 дугаар зүйлийн 32.3-д заасны дагуу дараах ажлын байранд ажиллах гадаад ажилтнаас ажлын байрны төлбөр авахгүй хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгож, бүртгэл хөтөлнө:

4.1.1. гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн байгууллагын тодорхойлолт, мэдээллийг үндэслэн гадаадын хөрөнгө оруулалттай компанийн ерөнхий захирал, гүйцэтгэх захирал, гадаадын хөрөнгө оруулагч, гадаадын хөрөнгө оруулагчийн төлөөлөгч;

4.1.2. гадаадын иргэний асуудал хариуцсан төрийн байгууллагын тодорхойлолт, мэдээллийг үндэслэн олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын удирдах ажилтан, ажилтан, сайн дурын ажилтан;

4.1.3. тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага, эсхүл төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, гадаад ажилтны мэргэжлийн баримт бичгийг үндэслэн боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, спортын байгууллагад гэрээгээр ажиллах соёлын ажилтан, эмч, эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжлийн багш, дасгалжуулагч;

4.1.4. онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт, мэдээллийн дагуу гамшгийн эрсдэл, түүний хор уршгийг арилгахаар ажиллаж байгаа ажилтан.

4.2. Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон Монгол Улсын Засгийн газраас тодорхойлсон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтад гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газрын шийдвэрээр ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө.

4.3. Ажил олгогч энэхүү журмын 4.2-т заасан чөлөөлөлтөд хамрагдах хүсэлтээ гадаад ажилтан ажиллах төсөл, хөтөлбөрийн танилцуулга, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн мэдээлэл, стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт гэж үзэх үндэслэл, баримт бичгийн хамтаар жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

4.4. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 4.3-т заасан ажил олгогчийн ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх хүсэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

4.5. Төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдэд ажиллах хүчний хомсдол бий болж, хэвийн үйл ажиллагаа хангагдах боломжгүй нөхцөл үүсч Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 23 дугаар зүйлийн 23.4-т заасны дагуу гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газрын шийдвэрээр ажлын байрны төлбөрөөс чөлөөлж болно.

4.6. Чөлөөт бүсийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д заасны дагуу чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсэн бол ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө.

4.7. Энэ журмын 4.5, 4.6-д заасны дагуу ажлын байрны төлбөрийг чөлөөлөх асуудлыг Засгийн газрын шийдвэрийн дагуу энэ журмын 4.3, 4.4-т зааснаас өөр хугацаанд шийдвэрлэж болно.

### **Тав. Ажлын байрны төлбөрийн зөрүүг буцаан олгох**

5.1. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авсан гадаадын иргэн тухайн ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээгээ хугацаанаас нь өмнө цуцалж буцсан, өөр байгууллагад шилжин ажилласан, зөвшөөрөл авсан боловч гадаад ажилтан Монгол Улсад ирж хөдөлмөр эрхлээгүй тохиолдолд ажлын байрны төлбөрийн зөрүү, урьдчилан төлсөн төлбөрийг тухайн ажил олгогчид буцаан олгоно.

5.2. Ажлын байрны төлбөрийн зөрүүг буцаан авах эрх үүссэн ажил олгогч энэ журмын 5.1-д заасан нөхцөл үүссэнээс хойш 60 хоногийн дотор нотлох баримт бичгийн хамт хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлт гаргана. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3 сараас дээш хугацаа хэтэрсэн хүсэлтийг хүлээн авахгүй.

5.3. Ажлын байрны төлбөрийн зөрүүгийн буцаалтыг ажил олгогчийн хүсэлт, гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолт, шилжин ажиллах тухай шийдвэрийг үндэслэн тухайн төсвийн жилд багтаан 30 хоногийн дотор буцаан олгоно.

5.4. Ажлын байрны төлбөрийн зөрүүг тогтоох хугацааг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтод заасан болон шилжин ажиллах тухай шийдвэрт заасан хугацаагаар тооцно.

5.5. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 26 дугаар зүйлийн 26.1-д зааснаар зөвшөөрлийг цуцалсан тохиолдолд ажлын байрны төлбөрийн зөрүүг буцаан олгохгүй.

### **Зургаа. Төлбөрийн бүртгэлийг хөтлөх, тайлан, мэдээ**

6.1. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажлын байрны төлбөр төлсөн, хөнгөлсөн, чөлөөлсөн, төлбөрийн зөрүүг буцаан олгосон тухай бүртгэлийг дараах байдлаар тухай бүр бүртгэнэ:

6.1.1. ажлын байрны төлбөр төлсөн бүртгэлийг төлбөр төлсөн баримт, мэдээллийг үндэслэн ажил олгогч, гадаад ажилтны мэдээлэл, тоо, Монгол Улсад хөдөлмөр эрхэлсэн, эрхлэх хугацаа, төлсөн төлбөрийн хэмжээний мэдээллийн хамт;

6.1.2. ажлын байрны төлбөрийг хөнгөлсөн, чөлөөлсөн бүртгэлийг тухай бүр Засгийн газар болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр, хуульд хөнгөлөх, чөлөөлөхөөр заасан үндэслэл, түүнийг нотлох баримтын хамт, ажил олгогч, гадаад ажилтан бүрээр;

6.2. Ажлын байрны төлбөрийн зөрүүг буцаан олгосон бүртгэлийг тухай бүр ажил олгогч, ажилтны мэдээлэл, холбогдох шийдвэрийн хамт бүртгэнэ.

6.3. Ажлын байрны төлбөртэй холбоотой бүртгэлийг хуурамчаар үйлдэх, бүртгэхгүй байх, бүртгэлд хууль бусаар засвар өөрчлөлт оруулахыг хориглоно.

6.4. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ажлын байрны төлбөрийн талаарх тайланг улирал тутам гаргаж, дараа улирлын эхний сарын 08-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, шаардлагатай тохиолдолд мөн оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор холбогдох бусад төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.5. Тайланд ажлын байрны төлбөр төлсөн нийт дүн, хөнгөлсөн, чөлөөлсөн, төлбөрийн зөрүүг буцаан олгосон дүн, ажил олгогч, гадаад ажилтны тоо, тухайн

жилийн төлөвлөгөөт орлогын гүйцэтгэлийн явц, тэдгээрт дүн шинжилгээ хийсэн тайлан, мэдээллийг тусгасан байна.

6.6. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ажлын байрны төлбөртэй холбоотой бүх мэдээллийг Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний цахим мэдээллийн санд тухай бүр бүртгэнэ.

6.7. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль (шинэчилсэн найруулга)-д заасны дагуу энэ журмын хэрэгжилтэд хяналт тавина.

6.8. Энэ журмыг зөрчсөн төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.9. Энэ журмыг зөрчсөний улмаас бусдад хохирол учруулсан бол Иргэний хуульд заасны дагуу буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлнэ.

--- оОо ---